“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН
2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН НЭГДҮГЭЭР УЛИРЛЫН БИЕЛЭЛТ

2019 оны 03 дугаар сарын 29 — Багануур дүүрэг

| Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн заалт | Зорилт | Үйл ажиллагаа | Хариуцах байгууллага | Шалгуур үзүүлэлт | Зорилтот түвшин | Гүйцэт-гэл, хувь | Үнэлгээ-ний хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | | 4 | 5 | 6 | 8 |
| НЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ – ӨРХ БҮРД | | | | | | | |
| 1.1. ҮЙЛДВЭРЛЭЛ, ИННОВАЦИЙГ ЦОГЦООР НЬ ХӨГЖҮҮЛНЭ. | | | | | | | |
| 1.1.1.4 Багануур дүүрэгт “Багануур үйлдвэрлэл, технологийн парк” байгуулах ажлыг эхлүүлнэ. | 1.5. Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийн ажлыг эхлүүлнэ. | 1.5.1. ХЕТ, инженерийн дэд бүтцийн зураг төслийг гүйцэтгүүлэн хүлээн авах | БХБЯ<br>БҮТП ОНӨТҮГ<br>“Мон-Энержи Консалт” ХХК | Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар | 100% | 50% | |
| | | 1. Бүсүүдийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөлт, гадна инженерийн дэд бүтцийн зураг төслийг Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж БХБЯ-руу батлуулахаар шилжүүлээд байгаа бөгөөд гүйцэтгэлд хяналт тавьж ажиллаж байна.<br>2. Гадна инженерийн шугам сүлжээний ажлын зураг гүйцэтгэх ажлын хүрээнд цахилгаан хангамжийн төлөвлөлтийн трассыг Багануурын уурхайн ашиглалтын бүсээс гарган дүүргийн Газрын алба, БЗӨБЦТС ТӨХК, БЗӨБЦДС ТӨХК-иудтай зөвшилцөн шинээр төлөвлөлт хийсэн.<br>3. Зураг төслийн дулаан болон цахилгаан хангамжийн техникийн нөхцөлийг авахаар ЭХЯ-нд материалыг хүргүүлсэн. | | | | | |
| | | 1.5.2. Багануур ҮТП-ийн дэд | БҮТП | Үйл ажиллагааны | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | бүтцийн бүтээн байгуулалтад шаардагдах хөрөнгө оруулалтын асуудлыг боловсруулж дээд шатны байгууллагуудад хүргүүлэх | ОНӨТҮГ | хэрэгжилт хувиар | 100% | 30% | |
| | | 1. “МУ-ын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн тодотголд паркийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг 2019-2021 онуудад тусгуулах тухай саналаа Үндэсний хөгжлийн газарт холбогдох материалуудын хамт 19 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Мөн Үндэсний хөгжлийн газрын хөрөнгө оруулалт хариуцсан ахлах мэргэжилтэн Түмэндэлгэрт паркийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын тооцоо, байгууллагын танилцуулгын хамт илгээсэн.<br>2. УУХҮЯ-аас Үндэсний хөгжлийн газарт Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын төслийг Засгийн газрын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тодотголоор оруулж санхүүжилтийг шийдвэрлүүлэх талаар албан ёсны хүсэлт тавьсан.<br>3. САТУ компанийн гүйцэтгэсэн паркийн байгаль орчны төлөв байдлын судалгааг БОАЖЯ хүлээн авч цаашид байгаль орчны нарийвчилсан үнэлгээ хийх тухай чиглэл өгсөн. Нарийвчилсан үнэлгээ хийх зардлыг Нийслэлийн төсөвт тусгуулах саналыг хүргүүлсэн. | | | | | |
| | | 1.5.4. Эрдэм шинжилгээ, шинэ бүтээлийн судалгаа, туршилтыг явуулах, инновацийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх ажлыг зохион байгуулна. | БҮТП ОНӨТҮГ | Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар | 100% | 30% | |
| | | 1. Паркийн дэргэд Паркийн инкубатор, инноваци, судалгааны төв /ПИИСТ/ байгуулах ажлын хүрээнд Физик техникийн хүрээлэн, Ерөнхий болон сорилын биологийн хүрээлэн, Ургамал хамгаалал эрдэм шинжилгээний хүрээлэн МУИС, ШУТИС-иудтай хамтран ажиллах талаар санал солилцож, гэрээний төслийг хүргүүлсэн. Дараа сард гэрээ байгуулан төлөвлөгөөний дагуу ажиллахаар төлөвлөж байна.<br>2. Монгол улсын Үндэсний хөгжлийн газар болон GIZ ЭТИС хөтөлбөр хамтран “Жижиг, дунд бизнесийн инновациудыг дэмжих сан”, “Залуу эрдэмтэд, гарааны | | | | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | бизнесийн инновациудыг дэмжих сан", "Бүтээлч сэтгэлгээ, медиа болон цахимжуулалтын төрлийн инновациудыг дэмжих сан" байгуулсан бөгөөд эдгээр сангуудын үйл ажиллагааг хэрэгжүүлэх хүрээнд:<br>▪ Үйлдвэрийн болон ахуйн хог хаягдлаар компост бордоо хийх үйлдвэр,<br>▪ Багануур цахилгаан механикийн үйлдвэрээс гарах төмрийн хаягдал хэрчдэсээр бэлэг дурсгалын зүйл хийх үйлдвэр,<br>▪ Багануурын нүүрсний уурхайн овоолгын шорооноос будаг гаргах үйлдвэр,<br>▪ Багануурын нүүрсний уурхайн овоолгын шорооны элсээр зүлгүүр хийх үйлдвэр<br>▪ Хүүхдийн модон тоглоомын үйлдвэр<br>байгуулах инновацийн урьдчилсан төслүүдийг боловсруулж 02.14-ны өдөр InnovationfundMongolia@gmail хаягаар Нийслэлийн Инновацийн санд хүргүүлсний үр дүнд дараах 2 төсөл эхний шатны шалгаруулалтад тэнцсэн. Үүнд:<br>• Багануурын нүүрсний уурхайн овоолгын шорооноос будаг гаргах үйлдвэр<br>• Үйлдвэрийн болон ахуйн хог хаягдлаар компост бордоо хийх үйлдвэр<br>3. Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5-д жижиг, дунд үйлдвэр, өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээ хөгжих орчныг бүрдүүлэх, ажлын байр бий болгох гэсэн заалтын хүрээнд дүүргийн ЖДҮДТ–тэй 2019.03.22-нд хамтран ажиллах Санамж бичиг байгуулж төлөвлөгөөний дагуу ажил эхэлсэн. | | |

ТАЙЛАН ХЯНАСАН:
БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК
ОНӨТҮГ-ЫН ДАРГА Ч.ЭЛБЭГСАЙХАН

ТАЙЛАН ГАРГАСАН:
ЭДИЙН ЗАСАГЧ, ТӨЛӨВЛӨЛТ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН: Б.МИЧИД-ЭРДЭНЭ